



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ**

Монгол Улс, 17032, Улаанбаатар хот,
Хан-Уул дүүрэг, Чингисийн өргөн чөлөө,
Утас: 70101153, Факс: (976) 70100005
E-mail: www.emd.gov.mn

2022.03.30 № 26
танай _____-ны № _____-т

УЛСЫН ИХ ХУРЛЫН НИЙГМИЙН
БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА М.ОЮУНЧИМЭГ ТАНАА

Эрүүл мэндийн даатгалын үндэсний
зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны тайлан болон
тайланд хийсэн системчилсэн үнэлгээний тайланг
хүргүүлж байна.

Хавсралт ⁶⁴.... хуудастай.

ДАРГА



С.ЭНХБОЛД

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН
2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

**УЛААНБААТАР ХОТ
2022 он**

АГУУЛГА

Нэг. Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, тогтоол шийдвэр, түүний хэрэгжилт

- 1.1 Эрүүл мэндийн даатгалын санг удирдах, нөөцийг зарцуулах талаар
- 1.2 Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээний төрөл, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх талаар хийгдэж буй шинэчлэл
- 1.3 Эрүүл мэндийн даатгалын байгууллагын бүтэц, зохион байгуулалтын талаар

Хоёр. Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв

- 2.1 Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв, төсвийн гүйцэтгэл
- 2.2 Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь, хэмжээ
- 2.3 Эрүүл мэндийн даатгалын хамралт
- 2.4 Эрүүл мэндийн даатгалын сангийн зарцуулалт

Гурав. Эрүүл мэндийн даатгалын хяналт, цахим систем, сургалт, сурталчилгаа

- 3.1 Эрүүл мэндийн даатгалын хяналт
- 3.2 Цахим систем
- 3.3 Сургалт, сурталчилгаа

Дөрөв. Дүгнэлт, санал, анхаарах асуудал

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УИХ	Улсын Их Хурал
НББСШУ	Нийгмийн Бодлого Боловсрол Соёл Шинжлэх Ухаан
ЗХХАУБ	Захиргааны хэм хэмжээний актын улсын бүртгэл
ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
СЯ	Сангийн яам
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
ЭЭХХЗГ	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар
ХХМТГ	Харилцаа, холбоо, мэдээлэл технологийн газар
ТЗ	Төрийн захиргаа
ЭМД	Эрүүл мэндийн даатгал
ЭМДБ	Эрүүл мэндийн даатгалын байгууллага
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМБ	Эрүүл мэндийн байгууллага
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
СЭМТ	Сумын эрүүл мэндийн төв
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ГТСМТТ	Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв
УҮГ	Улсын үйлдвэрийн газар

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

- Хүснэгт 1. Эрүүл мэндийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн 2021 оны жилийн эцсийн үлдэгдэл, тэрбум.төгрөг
- Хүснэгт 2. Тусламж, үйлчилгээний суурь тарифын хэмжээ, төгрөгөөр
- Хүснэгт 3. Тусламж үйлчилгээний тохиолдлын тоо болон санхүүжилт, төрлөөр, 2021 он
- Хүснэгт 4. Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний тохиолдлын тоо болон санхүүжилт, 2021 он
- Хүснэгт 5. Зайлшгүй шаардлагатай эмийн үнийн хөнгөлөлтийн зардал, 2018-2021 он, сая төгрөгөөр
- Хүснэгт 6. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэл, 2018-2021 он
- Хүснэгт 7. Өрх, сумын эрүүл мэндийн төвөөс үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэл, ЭМБ-аар, 2021 он
- Хүснэгт 8. 2019-2021 оны эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэл, сая төгрөгөөр
- Хүснэгт 9. Эрүүл мэндийн даатгалын 2018-2021 оны шимтгэлийн хувь, хэмжээ
- Хүснэгт 10. Эрүүл мэндийн даатгалын хамралтын байдал, 2018-2021 он
- Хүснэгт 11. Эрүүл мэндийн даатгалын сангийн зардлын гүйцэтгэл, 2021 он
- Хүснэгт 12. Даатгалын гэрээтэй эрүүл мэндийн байгууллагын тоо, 2019-2021 он

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

- График 1. Тусламж, үйлчилгээний тохиолдлын тоо болон олгосон санхүүжилт, даатгуулагчийн төрлөөр, хувиар
- График 2. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан хүний тоо, хувиар 2021 он
- График 3. Урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулсан эрүүл мэндийн байгууллага хувиар, 2021 он

СХЕМИЙН ЖАГСААЛТ

- Схем 1. Эрүүл мэндийн даатгалын байгууллагын бүтэц

ХАВСРАЛТ

Хавсралт. УИХ-ын Байнгын хорооны шийдвэр, чиглэлийн биелэлт

НЭГ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ, ТОГТООЛ ШИЙДВЭР, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ

Монгол Улсын Улсын Их Хурлаас Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд төр төлбөрийг хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн даатгалын сангаар дамжуулан худалдан авах талаар нэмэлт өөрчлөлт оруулснаар эрүүл мэндийн даатгалын тогтолцоонд томоохон шинэчлэлийг авчирсан.

Эрүүл мэндийн даатгалын энэхүү шинэчлэлийн талаар

- Даатгуулагчийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээ худалдан авдаг, хэрэглэгч, үйлчлүүлэгч төвтэй, нийгмийн хариуцлага бүхий эрүүл мэндийн даатгалын бие даасан тогтолцоог бүрдүүлэх;
- Эрүүл мэндийн даатгалын сангийн зарцуулалтад гүйцэтгэлийн санхүүжилтийг нэвтрүүлж, стратегийн худалдан авалтын тогтолцоонд шилжих
- Эрүүл мэндийн даатгалын хүртээмжийг нэмэгдүүлж, даатгуулагчийн эрхийг дээдэлж, даатгуулагчийг санхүүгийн эрсдэлээс хамгаалж, хамтын төлбөрийг шинэчлэх;
- Эрүүл мэндийн даатгалын мэдээллийн цахим сүлжээг үндэсний хэмжээнд нэвтрүүлж, мэдээллийн цахим сан бүрдүүлэх, системийн аюулгүй найдвартай байдлыг хангах гэсэн зорилтуудыг дэвшүүлж, үүнийг хэрэгжүүлэхэд санхүү, эдийн засаг, зохион байгуулалтын талаар шаардлагатай арга хэмжээг авч ажиллалаа.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл 2021 онд дэлхий нийтэд тархсан цар тахлын нөхцөлд Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа удирдлага болгон дээрх зорилтуудын хэрэгжилтийг хангах чиглэлээр зөвлөмж, шийдвэр гаргах, эрүүл мэндийн даатгалын үйлчилгээг даатгуулагчид ойртуулж, илүү хүртээмжтэй, өгөөжтэй болгох, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийг боловсронгуй болгоход үйл ажиллагаагаа илүүтэй төвлөрүүлэн ажиллаж, 2021 онд 13 тогтоол шийдвэр гаргасан.

2021 оны жилийн эцсийн байдлаар ЭМДҮЗ-ийн 22 тогтоол хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. ЭМДҮЗ нь 2021 онд эрүүл мэндийн даатгалын санг удирдан чиглүүлэх, нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр 8, эрүүл мэндийн даатгалын үйлчилгээний төрөл, чанар, хүртээмжийн талаар 4, ажлын албаны дотоод үйл ажиллагаатай холбоотой 1 тогтоолыг батлан гаргаж, хэрэгжилтийг хангуулж байна. Тайлант хугацаанд “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 03 дугаар тогтоол, “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” /өрх, сум, тосгон/ 04 дүгээр тогтоолыг шинэчлэн баталж Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлээ.

1.1 Эрүүл мэндийн даатгалын санг удирдах, нөөцийг зарцуулах талаар

2020-2021 онд тохиосон цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан Эрүүл мэндийн даатгалын санг удирдах, нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүллээ. Үүнд:

а/ Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орж, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед төсвийн зохицуулалт хийх зарим арга хэмжээний тухай” 168 дугаар тогтоол гарч, эрүүл мэндийн даатгалын сангийн чөлөөт мөнгөн хөрөнгийг төрийн сангийн нэгдсэн дансанд төвлөрүүлэх, эрсдэлийн сан байгуулах зэрэг арга хэмжээг авлаа.

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хуулиар батлагдсан орлого 951.3 тэрбум төгрөг, зарлага 1,210.7 тэрбум төгрөгийн төсвийн нарийвчилсан хуваарилалтыг хийв.

Эрүүл мэндийн даатгалын сан 2021 оны жилийн эцсийн байдлаар төрийн санд хадгаламж хэлбэрээр 100.0 тэрбум төгрөг, харилцах дансанд 162.1 тэрбум төгрөг, арилжааны 7 банкны харилцах дансанд 156.7 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

**Эрүүл мэндийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн
2021 оны жилийн эцсийн үлдэгдэл, тэрбум.төгрөг**

Хүснэгт 1.

№	Банкны нэр		Дансны үлдэгдэл
1	ХААН банк	Харилцах	15,509,287,180.67
2	Капитрон	Харилцах	21,199,895,987.76
3	Төрийн банк	Харилцах	73,985,054,939.52
4	Чингис ХААН банк	Харилцах	30,895,734,362.96
5	Голомт банк	Харилцах	2,906,990,500.52
6	Худалдаа хөгжлийн банк	Харилцах	9,026,946,160.48
7	Хас банк	Харилцах	3,218,858,382.30
8	Төрийн сан	Харилцах	162,052,323,038.11
9	Төрийн сан	Хадгаламж	100,000,000,000.00
Нийт			418,797,090,552.32

б/ Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар шинээр байгуулагдах үед Нийгмийн даатгалын байгууллагаас Капитал банканд эрүүл мэндийн даатгалын сангийн харилцах, хадгаламж хэлбэртэйгээр байршуулсан 132.5 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгө шилжин ирсэн.

Монголбанкны ерөнхийлөгчийн 2019 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А-96 дугаар тушаалаар “Капитал банк” ХХК-ийг албадан татан буулгаж, эрүүл мэндийн даатгалын санд томоохон хохирол учирсан. Энэ талаар эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас Банкны эрх хүлээн авагчид 2019 оны 05 дугаар сард нэхэмжлэлийн шаардлага хүргүүлж, Капитал банкны эрх хүлээн авагчийн 2019 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 1679 тоот албан бичгээр нэхэмжлэлийн шаардлагын хэмжээг 136,113,246,755.6 төгрөгөөр баталгаажуулсан.

ЭМДҮЗ нь даатгалын сангийн хөрөнгийг олж авах талаар чиглэл өгч, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар нь хууль, эрх зүйн хүрээнд сангийн хохирлыг шуурхай барагдуулахаар ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.

Капитал банк ХХК Банкны эрх хүлээн авагчаас цаашид зөвхөн зээлийн төлөлтөөр, мөнгөн хэлбэрээр даатгалд учирсан хохирлыг барагдуулах нь хугацаа их шаардах, бүрэн төлөгдөх эсэх нь эргэлзээтэй болох тул Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт Капитал банкны хөрөнгөнд бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгөөс нэхэмжлэлийн шаардлагад тооцож, өмчлөх эрхээр гаргаж, шилжүүлэн авах төлбөр барагдуулахыг санал болгон хөрөнгийн жагсаалт гаргаж ирүүлсэн.

Капитал банкнаас авах өрийг барагдуулахтай холбогдуулан ЭМДҮЗ-ийн 2021 оны "Өр төлбөр барагдуулах тухай" 06 дугаар тогтоолоор өр төлбөрт тооцон авах боломжтой 61.7 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий 74 үл хөдлөх хөрөнгийн жагсаалтыг баталж, биелэлтийг хангуулж байна. Түүнчлэн өр төлбөрт шилжүүлэн авч байгаа үл хөдлөх хөрөнгийг даатгалын сангийн авлагад хүлээн авах, хадгалах, хамгаалах, ашиглах, түрээслүүлэх, худалдан борлуулах журмыг тусгайлан гаргаж мөрдүүлж байна.

Энэ бүхний үр дүнд 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Капитал банк ХХК-наас авах өр төлбөрөөс 8.1 тэрбум төгрөгийг мөнгөн хэлбэрээр, 06 дугаар тогтоолын дагуу 36.4 тэрбум төгрөгийн үнэ бүхий 39 объект, 10 объектийг НДЕГ-тай хамтран шилжүүлэн авав. Авлагын үлдэгдэл 91.6 тэрбум төгрөгийг барагдуулах ажлыг 2022 онд үргэлжлүүлэн зохион байгуулахаар ажиллаж байна.

1.2 Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээний төрөл, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх талаар хийгдэж буй шинэчлэл

Эрүүл мэндийн салбарын хууль, эрхзүйн шинэчлэлээр Монгол Улсын Их Хурлаас Эрүүл мэндийн багц хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулж, төр төлбөрийг нь хариуцах тусламж, үйлчилгээг худалдан авах ажиллагааг Эрүүл мэндийн даатгалын байгууллага хариуцан гүйцэтгэх болов.

Эрүүл мэндийн даатгалын хуульд орсон өөрчлөлттэй холбоотойгоор ЭМДҮЗ нь төр төлбөрийг нь хариуцах тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалттай нэгтгэх замаар оношийн хамааралтай бүлгийн өртгийг бүхэлд нь шинэчлэн тогтоож, хэрэгжүүлж байна.

а/ Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг хариуцах эрүүл мэндийн багц тусламж, үйлчилгээ

ЭМДҮЗ-ийн шинэчлэн баталсан 2021 оны 03 дугаар тогтоолоор ЭМД-ын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийн жагсаалт, өртгийн жинг шинэчлэн баталсан бөгөөд уг тогтоолд нийт 120.2 мянган давхардсан онош багтаж байна. Тус тогтоолоор дараах өөрчлөлтүүд хийгдлээ. Үүнд:

- СЯ, ЭМЯ-ны саналын дагуу тусламж, үйлчилгээний суурь тарифыг 21-113 хувиар нэмэгдүүлсэн.

Тусламж, үйлчилгээний суурь тарифын хэмжээ, төгрөгөөр

Хүснэгт 2.

Тусламж, үйлчилгээний төрөл	ЭМДҮЗ 28 дугаар тогтоол	ЭМДҮЗ 03 дугаар тогтоол	Өсөлт (мөнгөн дүн)	Өсөлт (хувь)
Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ	400,000	850,000	450,000	113
Амбулаторийн үзлэг, хяналт, эмчилгээ, оношилгоо	15,000	30,000	15,000	100
Өдрийн эмчилгээ, үйлчилгээ	180,000	240,000	60,000	33
Хорт хавдрын хими, туяаны өдрийн эмчилгээ	450,000	450,000	-	-
Сэргээн засах тусламж, үйлчилгээ	250,000	250,000	-	-
Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ	400,000	485,000	85,000	21
Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээ	250,000	450,000	200,000	80

- Эрүүл мэндийн тухай хуулийн өөрчлөлттэй холбоотой Монгол улсын хүн амын эрүүл мэндийн эрэлт хэрэгцээг хангах, даатгуулагчийг санхүүгийн эрсдэлээс хамгаалах, ЭМД-ын тусламж, үйлчилгээний хүртээмж, үр ашгийг дээшлүүлэх зорилгоор амбулаторийн үзлэг, оношилгоо, шинжилгээний багц, амбулаторийн жижиг мэс ажилбар, амбулаторийн хяналтын үзлэг, уламжлалтын үзлэг, өндөр өртөг бүхий оношилгоо, шинжилгээ, өдрийн мэс засал, өдрийн уламжлалт эмчилгээ, өдрийн сэргээн засах тусламж, үйлчилгээний төрлүүдийг нэмж ЭМД-аас санхүүжүүлэхээр болгосон. Өмнө нь улсын төсвөөс санхүүжиж байсан төлбөрийг нь төр хариуцах жирэмсний хяналтын багц, диализын эмчилгээ, эрчимт эмчилгээ, яаралтай тусламж, түргэн тусламжийн төрлүүдийг багцад нэмж оруулж өргөжүүлэв.

- Уламжлалтын тусламж, үйлчилгээг өмнө нь оношоос үл хамааран ижил тарифаар санхүүжүүлдэг байсныг 14 ялгаатай оношийн бүлэг, мөн сэргээн засах тусламж, үйлчилгээг сэргээн засах тусламж, үйлчилгээг хөгжүүлэх бодлогыг баримталж 11 ялгаатай бүлэг болгохын зэрэгцээ, ялгаатай оношийн хамааралтай бүлэг бүрийн өртгийн судалгааг хийн, төлбөрийн хэмжээг тодорхойлсон.

- Тусламж, үйлчилгээний тусгай багц болон санхүүждэг байсан 650 нэр төрлийн “Өндөр өртөг бүхий мэс заслын тусламж, үйлчилгээний хэрэгсэл”-ийн зардлыг үндсэн мэс заслын өртөгт нь шингээсэн.

- Даатгуулагч хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад үйлчлүүлж, амбулаторийн болон өдрийн эмчилгээ, үйлчилгээ авах үед эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт олгогддоггүй байсныг өөрчилж, улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудыг ялгалгүйгээр эрүүл

мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний бүх төрлийн тусламж, үйлчилгээнд санхүүжилт олгохоор өөрчилсөн.

- Төрийн болон хувийн өмчийн эрүүл мэндийн байгууллагуудын ялгааг арилган, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагаас эрүүл мэндийн даатгалын бүх төрлийн тусламж, үйлчилгээг үзүүлэх боломжтой болсон нь байгууллага хоорондын өрсөлдөөнийг дэмжиж, даатгуулагчид өргөн сонголтыг бий болгож байна.

- Даатгуулагчид ЭМД-ын гэрээтэй эрүүл мэндийн байгууллагуудаар үйлчлүүлэхэд хамтын төлбөрөөс өөр нэмэлт төлбөр авахгүй байх нөхцөлийг бүрдүүллээ. Даатгуулагчийн тусламж, үйлчилгээ авахдаа төлөх хамтын төлбөрийн хэмжээг тухайн тусламж, үйлчилгээний нэн шаардлагатай байдал болон өртөг зардлын хэмжээнээс хамааруулан ялгаатай тогтоох болов. Жишээлбэл, улсын төсвөөс өмнө нь санхүүжүүлж байсан бүх тусламж, үйлчилгээнүүд болон амь, насыг аврах нэн шаардлагатай болон төрөлхийн гажигийн тусламж, үйлчилгээнүүд хамтын төлбөргүй, мэс заслын тусламж, үйлчилгээ 10-25 хувь, мэс заслаас бусад төрлийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ 10-15 хувь, өндөр өртөг бүхий оношилгоо, шинжилгээг 30 хувиар тогтоолоо. ЭМД-ын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.3-т заасан шимтгэлийг нь төр хариуцах иргэдийг хамтын төлбөрөөс чөлөөлөхөөр болов. Энэ нь тухайн иргэдийг санхүүгийн эрсдэлээс хамгаалах чухал алхам болсон гэж үзэж байна.

- Уг шинэчлэлийн хүрээнд 2021 онд эмнэлгийн тусламж, үйлчилгээний 5.4 сая тохиолдлын 550.3 тэрбум төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас гэрээ бүхий төрийн болон хувийн хэвшлийн 331 эрүүл мэндийн байгууллагад олгосон байна.

Тусламж, үйлчилгээний тохиолдлын тоо болон олгосон санхүүжилт, даатгуулагчийн төрлөөр, хувиар

График 1.



Тусламж, үйлчилгээний нийт тохиолдлын 69.5 хувь, санхүүжилтийн 76.0 хувийг эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь төр хариуцах иргэд буюу 0-18 насны хүүхэд, тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн, хүүхдээ асарч буй эх/эцэг, ял эдэлж байгаа ялтан, хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч нар

эзэлж байна. Энэ нь зорилтот бүлгийн хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг голлон үзүүлж, улмаар санхүүгийн эрсдэлээс хамгаалж, даатгуулагчийн төлсөн шимтгэлийн хэмжээнээс үл хамааран эрүүл мэндийн улмаас даатгуулагчид үүссэн санхүүгийн эрсдэлийг хуваалцах эв санааны нэгдлийн зарчимд тулгуурлана гэсэн хуулийн зарчимтайгаа нийцэж байгаа болно.

ЭМДҮЗ-ийн 03 дугаар тогтоолын дагуу эрүүл мэндийн даатгалын сангаас 12 нэр төрлийн тусламж, үйлчилгээний нийт 325 оношийн хамааралтай бүлгийн тусламж, үйлчилгээнд санхүүжилт олголоо. Үүнийг тусламж, үйлчилгээний нэр төрлөөр задалж үзвэл амбулаторийн тусламж, үйлчилгээ нийт тохиолдлын 71.2 хувийг, санхүүжилтийн 17.6 хувийг эзэлж байгаа бол хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ нийт тохиолдлын 7.2 хувь, харин санхүүжилтийн 59 хувийг тус тус эзэлж байна.

Тусламж, үйлчилгээний тохиолдлын тоо болон санхүүжилт, төрлөөр, 2021 он

Хүснэгт 3.

№	Тусламж, үйлчилгээний нэр төрөл	Тохиолдлын		Олгосон санхүүжилт	
		тоо	хувь	сая төг	хувь
1	Амбулаторийн тусламж, үйлчилгээ	3,896,017	71.2	96,751.4	17.6
2	Диализын тусламж, үйлчилгээ	155,983	2.9	16,059.8	2.9
3	Өдрийн эмчилгээ	24,289	0.4	5,395.4	1.0
4	Хорт хавдрын хими, туяаны өдрийн эмчилгээ	17,452	0.3	12,387.4	2.3
5	Өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээ	145,931	2.7	14,199.1	2.6
6	Сэргээн засах тусламж, үйлчилгээ	71,958	1.3	11,439.8	2.1
7	Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээ	48,706	0.9	13,721.6	2.5
8	Телемедициний тусламж, үйлчилгээ	792	0.1	31.0	0.0
9	Түргэн тусламж	379,296	6.9	16,303.0	3.0
10	Яаралтай тусламж	334,861	6.1	37,521.4	6.8
11	Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ	3,258	0.1	1,530.1	0.3
12	Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ	391,399	7.2	324,926.5	59.0
Нийт дүн		5,469,942	100	550,266.5	100

Тухайлбал,

- Амбулаторийн тусламж, үйлчилгээний 3.8 сая тохиолдолд 96.7 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна. Үүнээс амбулаторийн үзлэг болон амбулаторийн үзлэг, оношилгоо, шинжилгээ нийт тохиолдлын 76.9 хувь, санхүүжилтийн 70.8 хувь болж байна. Амбулаториор хийгдэх мэс ажилбар хамгийн бага буюу нийт тохиолдлын 0.9 хувь, санхүүжилтийн 0.8 хувь байна.

- Өдрийн эмчилгээний 24,289 тохиолдолд 5.4 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон. Өдрийн эмчилгээний нийт тохиолдлын 77.1 хувь, санхүүжилтийн 79.4 хувийг өдрийн эмийн эмчилгээ эзэлж байгаа бол үлдэх хувийг

өдрийн мэс заслын тусламж, үйлчилгээ эзэлж байна. Эмчийн заалтаар лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагад амбулаториор өдрөөр хийгдсэн мэс заслын хамгийн их тохиолдлыг арьсны идээт ба мөөгөнцөрт өвчнүүд (тохиолдлын 54.0 хувь, санхүүжилтийн 47.4 хувь) эзэлж байна.

- Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний нийт 391,399 тохиолдлын 75.9 хувь, санхүүжилтийн 51.6 хувийг (166.8 тэрбум төгрөг) эмийн эмчилгээ эзэлж байна. Харин мэс заслын тусламж, үйлчилгээ нийт тохиолдлын 21.1 хувь, санхүүжилтийн 39.5 хувийг (128.2 тэрбум төгрөг) эзэлж байгаа нь бусад төрлийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээтэй харьцуулахад өндөр байна.

Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний тохиолдлын тоо болон санхүүжилт, 2021 он

Хүснэгт 4.

№	Тусламж, үйлчилгээний төрөл	Тохиолдлын тоо	Олгосон санхүүжилт, сая төг
1	Мэс засал	82,666	128,293.9
2	Хорт хавдрын хэвтүүлэн эмчлэх хими, туяа эмчилгээ	3,689	6,233.3
3	Эмийн эмчилгээ	297,251	166,884.3
4	Эрхтэн шилжүүлэх мэс засал	46	4,056.8
5	Эрчимт эмчилгээ	7,747	19,458.2
Нийт дүн		391,399	324,926.5

б/ Эмийн үнийн хөнгөлөлтийн тусламж, үйлчилгээ

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл “Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хувь хэмжээ”-г тогтоож, 2020 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлж эхэлсэн ба 2021 онд амжилттай үргэлжлүүлэн хэрэгжүүллээ. Уг шийдвэрээр 141 ерөнхий нэршлийн, 541 худалдааны нэрийн эмэнд 30, 50, 70 хувийн хөнгөлөлтийг ЭМД-ын сангаас үзүүлэх болсон юм. Эмийн үнийн хөнгөлөлтийг гүйцэтгэлээр нь санхүүжүүлж, иргэн, даатгуулагчид өөрт хамгийн ойр байгаа эмийн сангаас эмийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээг хүндрэл, чирэгдэлгүй авах боломжтой болгов.

Эрүүл мэндийн даатгалын сангаас 2021 оны байдлаар 1731 эмийн сангаар дамжуулан 104.2 сая ширхэг эмийг хөнгөлөлттэй олгож 60.4 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Нийт олгосон санхүүжилтийн 50.4 хувь буюу 30.4 тэрбум төгрөгийг Улаанбаатар хотод байршилтай 849 гэрээт эмийн санд, орон нутгийн 877 эмийн санд нийт санхүүжилтийн 49.6 хувь буюу 29.9 тэрбум төгрөгийг тус тус олголоо.

2020 онд эмийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээг 1.5 сая даатгуулагчид үзүүлж, даатгалын сангаас 35.9 тэрбум төгрөгийг зарцуулж байсан бол 2021 онд 1731 эмийн сантай даатгалын гэрээ байгуулан 2.2 сая даатгуулагчид 60.4 тэрбум төгрөгийг зарцуулсан нь өмнөх оноос 24.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

**Зайлшгүй шаардлагатай эмийн үнийн
хөнгөлөлтийн зардал, 2018-2021 он, сая төгрөгөөр**

Хүснэгт 5.

Эрүүл мэндийн даатгалын сангийн зардал	2018 он		2019 он		2020 он		2021 он	
	Төсөв	Гүйцэтгэл	Төсөв	Гүйцэтгэл	Төсөв	Гүйцэтгэл	Төсөв	Гүйцэтгэл
Эмийн үнийн хөнгөлөлтийн зардал	30,881.6	25,914.0	33,987.3	33,401.6	43,228.8	35,934.3	60,400.0	60,400.0
Хүний тоо /мян.хүн/	1 435.5		1 593.9		1 524.6		2 256.0	

2021 онд “Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээ”-ний жагсаалтад шаардлагатай 33 худалдааны нэршлийн эмийг шинээр нэмж оруулсан.

Эмийн нэгдсэн худалдан авалтыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах ажлын хэсэг ЭМД-ын сангаас хөнгөлөлт үзүүлдэг эмийн зардалд сүүлийн 4 жилээр судалгаа хийж ЭМД-ын сангаас 100,0 сая төгрөгөөс дээш санхүүжилт авсан 10 нэр төрлийн эмийн жагсаалтыг гаргасан. Тус 10 нэр төрлийн эмийг олон улсын тендер зарлаж худалдан авах ажлыг ЭМЯ, ЭМДЕГ, ЭЭХХЗГ-тай хамтран зохион байгуулах бэлтгэл ажлыг хангаж эмийн нэгдсэн худалдан авалтаар авах боломжтой эмийн саналыг ЭМЯ-д хүргүүлэн ажилласан.

Хүн амын дунд зонхилон тохиолддог, нас баралтын хувь өндөртэй зүрх судас, чихрийн шижин, уушгины эмгэг болон хөхний хавдрын үеийн эм зүйн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор “Новартис эмийн хүртээмжийг сайжруулах” хөтөлбөрийг Монгол Улсад хэрэгжүүлэхээр Швейцарын Холбооны Улсын Новартис Глобал эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллаж байна. Хөтөлбөрийн хүрээнд халдварт бус өвчнөөр өвчилсөн иргэдийн эмчилгээнд хэрэглэх, Европын Холбооны эмийн өндөр зохицуулалттай орнуудад үйлдвэрлэгддэг 15 нэрийн эм хамгийн бага өртгөөр (нэг сарын хэрэглээний эм 1 /нэг/ ам.доллар) нийлүүлэгдэх боломжтой болох юм. Новартисын “Сандоз фармасеютикал” компанитай хөтөлбөрийг хэрэгжүүлэх гэрээ байгуулж хамтран ажиллах талаар харилцан тохиролцсоны дагуу “Новартисын эмийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөр”-ийг Монгол Улсад хэрэгжүүлэхэд хамтран ажиллах гэрээ байгуулахаар ажиллаж байна. Ингэснээр эрүүл мэндийн даатгалын сангийн ачааллыг бууруулах боломжтой гэсэн тооцоотой ажиллаж байна.

в/ Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх тусламж, үйлчилгээ

Иргэн даатгуулагчдад хамгийн ойр ажилладаг өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдийг ЭМДҮЗ бодлогоор дэмжиж ажиллалаа. Төр даах тусламж,

үйлчилгээг эрүүл мэндийн даатгалын сангаар дамжуулан санхүүжүүлэхтэй холбоотой анхан шатны “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 04 дүгээр тогтоолыг баталсан. Үүнд: нэг иргэнээр тооцсон төлбөрийн хэмжээ, тохиолдолд суурилсан төлбөрийн хэмжээ, санхүүжүүлэх журмыг тодорхой тусган оруулав. Үүний дагуу 198.6 тэрбум төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээр анхан шатны эрүүл мэндийн байгууллагад шилжүүлсэн.

Мөн ЭМДҮЗ-ийн 2019 оны 23, 2020 оны 14 дүгээр тогтоолын дагуу өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг хариуцах 4 төрлийн тусламж, үйлчилгээг санхүүжүүлж байна

Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэл, 2018-2021 он

Хүснэгт 6.

Тусламж, үйлчилгээний төрөл	2018 он		2019 он		2020 он		2021 он	
	Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн
Сэргээн засах тусламж, үйлчилгээ	42,838	946.3	70,794	1 957.2	59,763	2,230.4	63,366	2,543.7
Гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ	7,538	188.5	41,545	1 286.5	38,189	1,513.7	60,995	5.663,4
Өдрийн эмчилгээ	7,259	217.6	52,871	2 013.4	59,052	3,930.0	61,840	4.234,9
Оношилгоо шинжилгээ	24,571	368.7	287, 418	2729.0	340,376	4,015.2	258,173	2.693,9
Нийт дүн	82,206	1,720.1	452,628	8,986.1	497,380	11,690.4	444,374	15,135.9

2021 онд 444.3 мянган тохиолдолд 15.1 тэрбум төгрөг зарцуулсан байна. Өмнөх онтой харьцуулахад 53 мянган хүнээр буурсан бол, олгосон санхүүжилт нь 3.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнээс оношилгоо, шинжилгээний тусламж үйлчилгээ нийт тохиолдлын 58.1 хувь, санхүүжилтийн 17.8 хувийг тус тус эзэлж байна. Харин гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ нийт тохиолдлын 13.7 хувь, нийт санхүүжилтийн 37.4 хувийг эзэлж, 5.6 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон.

Өрх, сумын эрүүл мэндийн төвөөс үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэл, ЭМБ-аар, 2021 он

Хүснэгт 7.

№	ЭМБ-ын төрөл	ЭМБ-ын тоо	Тохиолдлын тоо	Хувь	Олгосон санхүүжилт /сая төг/	Хувиар
1	ӨЭМТ	297	13,854	3.1	4,776.2	31.6
2	СЭМТ	312	430,520	96.9	10,359.7	68.4
	Нийт дүн	609	444,374	100	15,135.9	100

Эрүүл мэндийн байгууллагын төрлөөр нь авч үзэхэд улсын хэмжээнд 297 ӨЭМТ-ийн үзүүлсэн тусламж, үйлчилгээний 13,854 тохиолдолд 4.8 тэрбум төгрөг,

312 СЭМТ-ийн үзүүлсэн тусламж, үйлчилгээний 430,520 тохиолдолд 10.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон.


г/ Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээ

ЭМД-аас шинэчлэлийн бодлогоор дэмжиж буй бас нэг арга хэмжээ бол иргэн бүрийг урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулахад чиглэж байна. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.1-т “Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, иргэн бүр урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд тогтмол хамрагдах нөхцөлийг олон улсын жишигт нийцүүлэн сайжруулж, эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ” гэсэн зорилт дэвшүүлсэнийг дэмжиж, тодорхой насны бүлгээр урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулж байна.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн баталсан 2018 оны 19, 2020 оны 01 дүгээр тогтоолоор “Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах журам болон үзлэгийн багц”-д 18-34 нас, 35-45 нас, 46-64 нас, 65-аас дээш насны даатгуулагчийг 4 насны бүлгээр урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд хамруулахаар баталсан.

Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан хүний тоо, хувиар 2021 он


График 2.



Тайлант онд гэрээ бүхий 202 ЭМБ-аар 18-аас дээш насны даатгуулагчдын 4.4 хувь буюу 96.8 мянган даатгуулагч даатгуулагчийг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлээс хамааруулан урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамрагджээ. Энэ арга хэмжээнд ЭМДС-аас 3.4 тэрбум төгрөг зарцууллаа. Өмнөх онтой харьцуулахад урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан хүний тоо 36.9 хувь буюу 56.3 мянган хүнээр, санхүүжилт 32.1 хувь буюу 2.1 тэрбум төгрөгөөр тус тус буурсан. Урьдчилан сэргийлэх үзлэгийн хамрагдалт өмнөх онтой харьцуулахад буурсан үзүүлэлттэй гарсан нь коронавируст халдварын цар тахлын үед Эрүүл мэндийн яам болон Улсын онцгой комиссоос өгсөн чиглэл болон бүх нийтийн хөл хориотой холбоотойгоор иргэд эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэх явдал багассантай холбоотой.

**Урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулсан эрүүл мэндийн
байгууллага хувиар, 2021 он**

График 3.



2021 онд нийт 96,805 даатгуулагч дунджаар гурван нэр төрлийн оношилгоо, шинжилгээ хийлгэсэн ба давхардсан тоогоор нийт 1,785,203 оношилгоо, шинжилгээний үзүүлэлтүүдийг тодорхойлуулсан нь нэг даатгуулагч дунджаар гурван нэр төрлийн оношилгоо, шинжилгээ хийлгэсэн байна.

Монгол улсын Засгийн газраас 2022 онд иргэн бүрийг урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулахаар шийдвэрлэсний дагуу холбогдох тогтоол, журмыг шинэчлэхээр төлөвлөн ажиллаж байна.

е/ Коронавируст халдварын үеийн тусламж, үйлчилгээний талаар

Коронавируст халдварт цар тахлын дэгдэлтийн үед Эрүүл мэндийн даатгалын сангаас эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааг тасалдуулахгүйн тулд цаг тухайд нь тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг урьдчилгаа болон гүйцэтгэлээр санхүүжилтийг олгож ажиллалаа.

2021 оны байдлаар Коронавируст халдвараар өвчилсөн 268,107 иргэний хэвтэн эмчлүүлэх зардалд давхардсан тоогоор 2667 ЭМБ-аар дамжуулан 285.4 тэрбум төгрөг, гэрээр тусгаарлагдсан 477,278 иргэнд давхардсан тоогоор 1451 өрхийн эмнэлгээр дамжуулан 44.6 тэрбум төгрөг, мөн 543 ЭМБ-аар дамжуулан 4,428,731 иргэний вакцинжуулалтын зардалд 22.1 тэрбум төгрөг, 68 ЭМБ-аар дамжуулан 304696 иргэний сорьц шинжлэх зардалд 15.2 тэрбум төгрөг, 123 ЭМБ-аар дамжуулан 2,271,157 иргэний сорьц авах ПГУ зардалд 1.1 тэрбум төгрөг, нийт давхардсан тоогоор 4852 ЭМБ-аар дамжуулан давхардсан тоогоор 7,749,969 иргэнд 368.6 тэрбум төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас зарцууллаа.

1.3 Эрүүл мэндийн даатгалын байгууллагын бүтэц, зохион байгуулалтын талаар

Улсын Их Хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн чуулганаар Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орж, уг хуулиар эрүүл


мэндийн даатгалын байгууллага нь стратегийн худалдан авалтын тогтолцоонд шилжих шинэ нөхцөл байдал буй болж, хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүртээмжтэй үзүүлэх, тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх, тусламж, үйлчилгээ үзүүлэгчдийн гүйцэтгэлийг үнэлэх зэрэг хууль, эрх зүйн өргөн хүрээтэй ажиллах үүргийг биелүүлэх болсон юм.

Энэ бодлого зорилтыг хангах үүднээс Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 176 дугаар тогтоолоор агентлагийн орон тооны дээд хязгаарыг 170 байхаар шинэчлэн тогтоосон. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасны дагуу Эрүүл мэндийн даатгалын бие даасан тогтолцоог бүрдүүлэх, бодлогын болон үйл ажиллагааны зөв менежмент, маркетингийг хөгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авч, 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 17 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын бүтцийг шинэчлэн баталсан.

Үндэсний зөвлөлийн Эрүүл мэндийн даатгалын байгууллагын бүтцийг баталсан шийдвэрийн дагуу Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын бүтэц, зохион байгуулалт шинэчлэгдэж, 2021 оноос 21 аймаг, Багануур, Налайх дүүргийн эрүүл мэндийн даатгалын тасгийг өргөжүүлэн “Эрүүл мэндийн даатгалын хэлтэс”-ийг байгуулан үйл ажиллагаагаа явуулах болов.

Эрүүл мэндийн даатгалын байгууллагын бүтэц

Схем 1.



Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар нь 5 газар, 7 хэлтэс, 153 албан хаагчтай ажиллаж байна. Эрүүл мэндийн даатгалын байгууллагад нийт 222 ажилтантай, үүнээс төрийн захиргааны албан хаагч 183 буюу 82.4 хувь, төрийн үйлчилгээний 39 буюу 17.6 хувь байна. Удирдах албан тушаалтан 36, гүйцэтгэх албан тушаалтан 147 байна. Төрийн захиргааны албан хаагчаас ахлах түшмэл 33, дэс түшмэл 70, туслах түшмэл 1, 45 улсын байцаагч ажиллаж байна. Мэргэжлээр нь авч үзвэл эмч 37.4 хувь, санхүүч, эдийн засагч, нягтлан бодогч 40.0 хувь, эрх зүйч 5.9 хувь, бусад мэргэжил 16.7 хувийг тус тус эзэлж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 217 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г гаргаж хэрэгжилтийг ханган ажилласан. Төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 51 арга хэмжээг төлөвлөн, 80.7% биелэлттэй ажилласан.

ХОЁР. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСӨВ

2.1 Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв, төсвийн гүйцэтгэл

“Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хууль”-иар Эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлэх нийт орлогын хэмжээ 951.2 тэрбум төгрөг, даатгалын сангийн төсвийн нийт зарлагын хэмжээ 1,210.7 тэрбум төгрөг байхаар тус тус баталсан.

Орлогын гүйцэтгэл: Эрүүл мэндийн даатгалын санд 2021 онд 1,002.0 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, орлогын төлөвлөгөө 105 хувьтай биелсэн нь өмнөх оны орлогын гүйцэтгэлтэй харьцуулахад 11 хувиар өссөн. Үүнээс шимтгэлийн орлого 491.5 тэрбум төгрөг буюу өмнөх оны гүйцэтгэлээс 16 хувиар, бусад орлого 510.4 тэрбум төгрөгөөр буюу өмнөх оны гүйцэтгэлээс 4 хувиар тус тус өссөн байна.

Зарлагын гүйцэтгэл: Эрүүл мэндийн даатгалын сангаас 1,159.2 тэрбум төгрөгийн тусламж, үйлчилгээний зардлыг гүйцэтгэлээр тооцон бүрэн олгож, эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардалд 7.5 тэрбум төгрөг, НДЕГ-т олгох зардалд 1.1 тэрбум төгрөг, бусад зардалд 40.2 тэрбум төгрөг, Нийгмийн даатгалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4 дэх заалтыг үндэслэн илүү төлсөн шимтгэлээ буцаан авах хүсэлт гаргасан даатгуулагчдад эрүүл мэндийн даатгалын сангаас 79.9 сая төгрөгийг буцаан олгоход тус тус зарцуулсан. Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагын 2021 оны төсвийн гүйцэтгэл 1,208.1 тэрбум төгрөг буюу 99.8 хувьтай байгаа ба өмнөх оны гүйцэтгэлээс 13 хувиар нэмэгдсэн байна.

Эрүүл мэндийн даатгалын төсөв, түүний гүйцэтгэлийн байдлыг өмнөх жилүүдийн байдалтай харьцуулахад тайлант оны хувьд эрүүл мэндийн даатгалд даатгуулагчаас төлөх шимтгэлийн орлогын хувь хэмжээ өмнөх оноос 71.0 тэрбум төгрөгөөр өссөн нь ажил олгогч, даатгуулагчийн төлөх шимтгэлийн нийт орлого нь төлөвлөгөөнөөс 50.9 сая төгрөгөөр буюу 114.3 хувиар давсан үзүүлэлттэй

холбоотой юм. Үүнээс: Аймаг, орон нутгийн хувьд 112.6 хувиар, нийслэлд 115.1 хувиар биелсэн.

Харин тайлант оны байдлаар 2,058 мянган даатгуулагч /давхардаагүй тоо/-ийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулж, 1,159.2 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

2019-2021 оны эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэл, сая төгрөгөөр

Хүснэгт 8.

Эрүүл мэндийн даатгалын сан		2019 он		2020 он		2021 он	
		Төсөв	Гүйцэтгэл	Төсөв	Гүйцэтгэл	Төсөв	Гүйцэтгэл
А. ОРЛОГО		407,667.3	469,419.8	506,538.2	476,515.4	951,266.4	1,002,031.6
1	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	368,334.6	426,881.0	448,903.8	420,510.8	443,171.9	491,583.6
2	Бусад орлого	39,332.7	42,538.8	57,634.4	55,710.1	508,094.5	510,448.0
Б. ЗАРЛАГА		405,667.3	350,956.4	494,538.3	426,379.5	1,210,703.3	1,208,111.1
1	Тусламж, үйлчилгээний зардал	399,171.3	346,127.8	467,759.9	410,725.6	1,159,216.0	1,159,182.5
2	Үйл ажиллагааны зардал	5,422.4	4,569.1	5,438.4	4,749.3	8,578.3	7,537.7
3	ШШБА-ны урамшуулал	800.0	0.5	-	-	-	-
4	НДЕГ-т олгох			1,100.0	1,100.0	1,100.0	1,100.0
5	Илүү төлсөн шимтгэлийн буцаан олголт	273.6	259.0	240.0	204.6	80.0	79.9
6	Эрсдэлийн сангийн хөрөнгө	-	-	20,000.0	9,600.0	-	-
7	Бусад	-	-	-	-	41,729.0	40,211.0

2.2 Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь, хэмжээ

Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд зааснаар Монгол Улсын бүх иргэн эрүүл мэндийн даатгалд албан журмаар даатгуулах үүрэгтэй бөгөөд даатгуулагчийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хэмжээг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар жил бүр тогтоож байна. Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд аж ахуйн нэгж, байгууллага, ажилтны сард төлөх шимтгэлийн хэмжээг түүний хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 4-өөс доошгүй хувиар, их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн суралцагч, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, малчин, ажил хөдөлмөр эрхлээгүй иргэн болон 0-18 насны хүүхдийн эрүүл мэндийн даатгалын сарын шимтгэлийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1-ээс доошгүй хувиар, бусад даатгуулагчийн эрүүл мэндийн даатгалын сарын шимтгэлийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 2-оос доошгүй хувиар тогтоохоор тус тус заасан.

**Эрүүл мэндийн даатгалын 2018-2021 оны
шимтгэлийн хувь, хэмжээ**

Хүснэгт 9.

№	Даатгуулагчдын төрөл	Шимтгэлийн 2018 оны хэмжээ	Шимтгэлийн 2019 оны хэмжээ	Шимтгэлийн 2020 оны хэмжээ	Шимтгэлийн 2021 оны хэмжээ	Төлөх хугацаа
1	Аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан	Хөдөлмөр хөлс түүнтэй адилтгах орлогын 4-өөс доошгүй хувиар, үүнээс ажил олгогч 2 хувь, ажилтан 2 хувь				Сар бүр
2	0-18 насны хүүхэд					
3	Их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн суралцагч	2400 төгрөг /Хөдөлмөр хөлсний доод хэмжээний 1%/	3200 төгрөг /Хөдөлмөр хөлсний доод хэмжээний 1%/	4200 төгрөг /Хөдөлмөр хөлсний доод хэмжээний 1%/	4200 төгрөг /Хөдөлмөр хөлсний доод хэмжээний 1%	Хагас, эсхүл бүтэн жилээр
4	Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, малчин, тодорхой хөдөлмөр эрхлээгүй иргэн	2400 төгрөг /Хөдөлмөр хөлсний доод хэмжээний 1%/	3200 төгрөг /Хөдөлмөр хөлсний доод хэмжээний 1%/	4200 төгрөг /Хөдөлмөр хөлсний доод хэмжээний 1%/	4200 төгрөг /Хөдөлмөр хөлсний доод хэмжээний 1%/	Хагас, эсхүл бүтэн жилээр
5	Төрөөс шимтгэлийг нь хариуцан төлөх иргэн	4800 төгрөг /Хөдөлмөр хөлсний доод хэмжээний 2%/	6400 төгрөг /Хөдөлмөр хөлсний доод хэмжээний 2%/	8400 төгрөг /Хөдөлмөр хөлсний доод хэмжээний 2%/	8400 төгрөг /Хөдөлмөр хөлсний доод хэмжээний 2%/	Сар бүр

ЭМД-ын шимтгэлийн хувь хэмжээг сүүлийн 5 жилд нэмэгдүүлээгүй, тогтвортой барих чиглэлийг Үндэсний зөвлөл баримтлан ажиллав.

2.3. Эрүүл мэндийн даатгалын хамралт

2021 онд 3,251.4 мянган даатгуулагч эрүүл мэндийн даатгалд хамрагдаж, хамралтын түвшин 96.8 хувьтай байна.

Эрүүл мэндийн даатгалын хамралтын байдал, 2018-2021 он

Хүснэгт 10.

№	Хамралтын төрөл	Даатгуулагчийн тоо /мянган хүн/			
		2018 он	2019 он	2020 он	2021 он
1	Аж ахуйн нэгж байгууллагын ажилтан	745.2	735.0	831.2	610.2
2	Аж ахуйн нэгжийн эзэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, ажилгүй иргэн	175.0	119.4	162.5	149.1
3	Их дээд, сургууль болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд суралцагч	47.2	19.7	25.6	19.03
4	Малчин	93.0	67.6	76.2	58.4
5	Гадаадын харьяалалтай иргэн	0.1	0.2	0.1	0.5
6	ЭМД-ыг төрөөс хариуцдаг иргэн	1,761.4	1,978.7	1,902.8	2,409.0
7	Ял эдэлж буй хоригдол	2.8	-	1.1	5.1
Нийт		2,824.7	2,920.6	2,999.7	3,251.4
Хувь		88.9	90.2	90.9	96.8

Аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, ажилгүй иргэн, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төрөөс хариуцдаг иргэний эрүүл мэндийн даатгалын хамралт өмнөх онтой харьцуулахад нэмэгдсэн байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газартай 2021 оны хамтран ажиллах 2021/11, НД-19 тоот гэрээг байгуулж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Батлан хамгаалах яамдуудтай 2020 оны 06 дугаар сард байгуулсан гэрээг үргэлжлүүлэн хамтран ажиллаж байна.

2.4 Эрүүл мэндийн даатгалын сангийн зарцуулалт

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хуулиар эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагыг 1,210.7 тэрбум төгрөг, үүнээс эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардалд 1,159.2 тэрбум, Эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардалд 14.8 тэрбум, Нийгмийн даатгалын байгууллагад 1.1 тэрбум төгрөг, илүү төлсөн шимтгэлийн буцаан олголтод 80.0 сая төгрөг тус тус зарцуулахаар баталсан.

Эрүүл мэндийн салбарт санхүүжилтийн шинэчлэлийг хэрэгжүүлж, эрүүл мэндийн байгууллагуудаас үзүүлсэн тусламж, үйлчилгээг гүйцэтгэлд үндэслэн санхүүжүүлэхээр хууль, эрх зүйн орчныг бүрдүүлсэн бөгөөд Эрүүл мэндийн даатгалын сангаас 2021 онд тусламж, үйлчилгээний зардалд 1,159.2 тэрбум төгрөг олгохоор төлөвлөснөөс гүйцэтгэлээр тооцон 100 хувь олгож, үйл ажиллагааны зардалд 7.5 тэрбум төгрөг, Нийгмийн даатгалын байгууллагад 1.1 тэрбум төгрөг, илүү төлсөн шимтгэлийн буцаан олголтод 79.9 сая төгрөгийг тус тус зарцууллаа.

Эрүүл мэндийн даатгалын сангийн зардлын гүйцэтгэл, 2021 он

Хүснэгт 11.

№	Нэр	Төлөвлөгөө /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	хувь
1	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний тусгай зориулалтын шилжүүлэг	198,672.9	198,672.9	100
2	Эрүүл мэндийн байгууллагад олгох тусламж үйлчилгээний санхүүжилт	854,026.4	854,026.4	100
3	ХЗДХЯ, БХЯ, ХНХЯ ны эрүүл мэндийн байгууллагад олгох тусламж үйлчилгээний зардалд	29,380.7	29,380.7	100
4	Суманд ЭМД-аас олгох санхүүжилт	10,359.7	10,359.7	100
5	Өрхөд ЭМД-аас олгох санхүүжилт	4,776.3	4,776.3	100
6	"Элэг бүтэн Монгол" хөтөлбөр оношилгоо шинжилгээний зардал	800.0	800.0	100
7	Элэг бүтэн Монгол хөтөлбөр эмийн үнийн хөнгөлөлт	800.0	766.3	95.8
8	ЭМД-ын сангаас санхүүжих эмийн үнийн хөнгөлөлт	60,400.0	60,400.0	100
9	Нийгмийн даатгалын байгууллагад олгох	1,100.0	1,100.0	100
10	Илүү төлсөн шимтгэлийн буцаан олголт болон бусад зардал	80.0	79.9	100
11	Бусад ангилагдаагүй нөөц хөрөнгө	41,729.0	40,211.0	96.4
12	ЭМДБ-ын үйл ажиллагааны зардал	8,578.2	7,537.6	87.9
	НИЙТ	1,210,703.3	1,208,111.1	99.8

2021 онд эрүүл мэндийн 2577 байгууллагатай ЭМД-ын байгууллага гэрээтэй ажиллаж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлсэн байна.

**Даатгалын гэрээтэй эрүүл мэндийн байгууллагын тоо,
2019-2021 он**

Хүснэгт 12.

№	ЭМБ-ын төрөл, тусламж, үйлчилгээний ангилал	2019 он	2020 он	2021 он
1	Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага	102	103	74
2	Хувийн эмнэлэг	179	179	197
3	Рашаан сувилал	58	58	48
4	Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв	424	459	527
5	Эмийн сан	1009	1627	1731
6	Элэгний В,С вирусийн идэвхжил тодорхойлох лаборатори	28	26	-
7	Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг багцын шинжилгээ	150	156	-
8	Гемодиализийн тусламж, үйлчилгээ	11	11	-
9	"Эрүүл шүд-Эрүүл хүүхэд" хөтөлбөр	161	147	-
10	Спорт клуб	-	13	-
Нийт		2122	2779	2577

Тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа гэрээтэй эрүүл мэндийн байгууллагын тоо өмнөх оноос 202-оор буурч, харин эмийн сан 2021 онд өмнөх оноос 104-өөр өслөө.

**ГУРАВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХЯНАЛТ,
ЦАХИМ СИСТЕМ, СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА**

3.1 Эрүүл мэндийн даатгалын хяналт

Эрүүл мэндийн даатгалын дотоод хяналтын нэг хэлбэр нь Үндэсний зөвлөлийн гаргасан шийдвэрийн биелэлтийг эргэж тайлагнах явдал юм. Үндэсний зөвлөлийн ажлын албанаас хяналт тавьж, 2021 онд 8 тогтоол, журмын гүйцэтгэлийг гаргуулж, танилцуулсан. ЭМДЕГ-аас 2021 онд хяналт, шалгалтад нийт төв, орон нутгийн 56 гэрээт байгууллагад төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт, шалгалт хийж, 20 байгууллагад мэргэжил арга зүйн зөвлөмж өгч, хяналтын үйл ажиллагаагаар илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүр засуулсан.

Тухайлбал давхардсан тоогоор нийт гэрээт 54 эрүүл мэндийн байгууллагад ЭМДҮЗ-ийн 03 дугаар тогтоолын хэрэгжилт болон гэрээний хэрэгжилтэд газар дээр нь хяналтыг хийж, улсын байцаагчийн 5 албан шаардлагыг хангуулж, нийт 28,2 сая төгрөгийн санхүүжилтийг зөрчил гаргагч байгууллагуудын санхүүжилтээс бууруулж, даатгалын санг хохиролгүй болгосон бол иргэн, даатгуулагчаас авсан нэмэлт төлбөр болох нийт 33.8 сая төгрөгийг иргэн, даатгуулагчид буцаан олгуулах арга хэмжээг авсан.

Тайлант хугацаанд удирдлагын баталсан удирдамж, чиглэлийн дагуу 27 удаагийн хяналт-шинжилгээ, үнэлгээг хийлгэж, холбогдох саналыг Үндэсний зөвлөлийн хуралд танилцуулан эрүүл мэндийн байгууллагад 9 албан шаардлага, 3 акт, 11 зөвлөмж өгсөн байна.

ЭМДҮЗ-ийн 2021 оны 05 дугаар тогтоолоор “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтын журам”-ыг боловсруулж баталсан. Энэхүү журмын хэрэгжилтийг хангах зорилгоор ЭМБ-аас ирүүлсэн нэхэмжлэлийг хянах үйл ажиллагаа, төлбөр гүйцэтгэх үйл явц, нэхэмжлэлийн хяналтын тайлан, хяналтын үр дүнд дүн шинжилгээ хийх, хариу арга хэмжээ авах, ЭМБ-д мэдээлэх, эргэх холбоо тогтоох зорилго бүхий “Нэхэмжлэлийн хяналт хийх журам”-ыг боловсруулж, ЭМДЕГ-ын даргын 2021 оны А/98 дугаар тушаалаар баталсан байна. Тушаалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Эрүүл мэндийн даатгалын цахим системд хөгжүүлэлт хийх, нэмэлт өөрчлөлт оруулах програмын бодлогын даалгавар”-ын цахим системийн хөгжүүлэлт 80 хувьтай байна.

3.2 Цахим систем

Эрүүл мэндийн даатгалын байгууллагын төлбөр, тооцоо, даатгуулагчид болон ажил үйлчилгээ худалдан авах байгууллагуудтай харилцах, даатгалын санд хяналт тавих ажиллагаа цахим хэлбэрт шилжүүлсэн байна. Энэ талаар Үндэсний зөвлөл, ЭМДЕГ-аас сүүлийн 3 жилд орчин үеийн мэдээллийн технологийн боломж, нөөцийг ашиглан, гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллагуудыг эрүүл мэндийн даатгалын системтэй цахимаар холбох, цахим баримтын системтэй уялдуулан мэдээллийг хянах тогтолцоог хөгжүүлэхээр зорьсон нь тодорхой үр дүн гарах болов. Тухайлбал:

- *Эрүүл мэндийн даатгалын цахим системийг үе шаттайгаар хөгжүүлэх арга хэмжээ авч байна.* Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, “Цахим Монгол” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, цахим системд холбогдсон бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудыг иргэд, даатгуулагчдад үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэл, үр дүнд үндэслэн санхүүжүүлэх болов. Шинэчлэлийн хүрээнд ЭМД-ын цахим систем нь “ГТСМТТ” УҮГ-ын “Нэвтрэлтийн нэгдсэн систем”-д холбогдож, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний API сервист нэмэлтээр 17 төрлийн сервисийн хөгжүүлэлт хийлээ. Гэрээ бүхий 2577 төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага, эмийн сан ЭМД-ын цахим системд бүртгэгджээ. Эрүүл мэндийн систем нийлүүлэгч 11 байгууллагын цахим системээр дамжуулан 120 гаруй төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага бодит цаг хугацаанд буюу real time-аар мэдээлэл солилцож байна.

- *E-Mongolia төрийн нэгдсэн системд нэгдлээ.* Иргэд, даатгуулагчид “E-Mongolia” төрийн нэгдсэн системээс 2016 оноос хойших эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтийн мэдээллийг харах, төлөгдөөгүй шимтгэлийг нөхөж төлөх боломжийг бүрдүүлэхэд ХХМТГ, НДЕГ, ЭМДЕГ-ын хамтарсан гэрээ хийгдэж, холбогдох дата мэдээлэл дээр ажиллаж байна. Нийт даатгуулагчдын авсан тусламж үйлчилгээний онош, ЭМБ-ын нэр харагдах боломжтой болгох шинэчлэлтийн хүрээнд нийт 23 сая мөр бичлэгийн ЭМБ-ын нэр, 20 сая мөр бичлэгийн оношийн кодыг оруулсан дүнтэй байна.

E-Mongolia, Хур системрүү эрүүл мэндийн даатгал шимтгэл төлөлт харуулах сервис хүлээлгэж өгсөн.

- Олон улсын эмнэлзүйн удирдамжийн цахим санг нэвтрүүлээ. Нэхэмжлэлийн нарийвчилсан хяналт хийх ерөнхий болон эмнэлзүйн нийт 230 шалгуурыг ЭМД-ын цахим програмд оруулж өдөр тутмын цахим хяналтад ашигладаг боллоо.

- Edaatgal аппликейшний "Дан" системд холбогдох ажил хийгдэж байна. Edaatgal аппликейшнд бүртгүүлэх иргэдийн бүртгэлийг иргэний үнэмлэхээр нь баталгаажуулдаг болгох зорилгоор Тагнуулын ерөнхий газрын Мэдээллийн аюулгүй байдлын газар, Улсын бүртгэлийн газраас тус тус албан зөвшөөрөл авч, "Үндэсний дата төв" УТҮГ-т хүсэлт хүргүүлэн, иргэнийг иргэний үнэмлэхийн QR кодоор баталгаажуулах сервис холбогдох эрхийг аваад байна. Мөн Үндэсний дата төвд "Дан" танилт нэвтрэлтийн нэгдсэн системд холбогдох сервисийг авах гэрээний бэлтгэл ажил хангагдлаа. Уг сервисийг авснаар системд нэр болон нууц үг хадгалах шаардлагагүй болох, бүртгэлийн давхардлыг бууруулах, мэдээллийн аюулгүй байдлыг нэг цэгээс хянах боломж бүрдэх юм.

3.3 Сургалт, сурталчилгаа

а/ Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын албан ёсны www.emd.gov.mn цахим хуудсанд байгууллагын үйл ажиллагаа, эрүүл мэндийн даатгалын сангаас үзүүлэх тусламж, үйлчилгээ болон цахим системийн талаарх шинэ мэдээллүүд, эрүүл мэндийн байгууллагуудын хаяг байршил зэрэг шаардлагатай мэдээллийг тухай бүрд шуурхай ил тодоор байршуулан иргэд даатгуулагчид болон эрүүл мэндийн байгууллагуудын ажилтнуудыг мэдээ, мэдээллээр хангах боломжтой болсон. Жилийн эцсийн байдлаар 283 үйл явдал, цаг үеийн мэдээ, сурвалжлага бэлтгэн мэдээлсэн нь давхардсан тоогоор 2,147.0 мянга гаруй хүнд хүрсэн байна.

б/ "Хэрэглэгчдэд үйлчлэх төв"-ийг байгуулснаар үйл ажиллагаа нь тогтмолжиж, 2021 онд тус төвийн 1800-1363 утсаар нийт 105,809 иргэдэд мэдээлэл, зөвлөгөө өгч ажилласан бөгөөд өмнөх оноос 44.3 мянгаар нэмэгдсэн байна.

в/ Эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтийн үйлчилгээг иргэдэд хялбар болгох зорилгоор Төрийн үйлчилгээний төлбөрийн нэгдсэн системд E-Mongolia болон eBagimt аппликейшн ашиглан хувиараа хөдөлмөр эрхлэгч, тодорхой хөдөлмөр эрхлээгүй бусад иргэн, оюутан, малчин, гадаадын иргэн харьяалалгүй хүн албан журмын эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ төлөх бүрэн боломжтой юм. 2021 оны байдлаар 45,505 иргэн тус аппликейшныг татан авч хүсэлтээ баталгаажуулсан бөгөөд үүнээс 41,711 иргэн, даатгуулагч идэвхтэй хэрэглэж байна. Бүртгэл дутуу 3,794 иргэн рүү эргэн холбогдож, E-daatgal аппликейшныг хэрхэн ашиглах бүртгүүлэх заавар зөвлөгөөг өгчээ.

г/ 2021 оны жилийн эцсийн байдлаар ЭМДЕГ-ын фэйсбүүк пэйж хуудас болон веб сайтад нийт 1069 контент бэлтгэн, түгээсэн. Үүнээс 283 нь үйл явдлын мэдээ, сурвалжлага, 619 нь зурган постер болон 139 видеог бэлтгэн ЭМДЕГ-ын

албан ёсны вэбсайт болон сошиал сувгуудад байршуулсан нь давхардсан тоогоор 7.5 сая гаруй хүнд хүрсэн дүн гарчээ. Мөн “Нэг сэдэв – Нэг тайлбар” видео, постер, долоо хоног бүр тогтмол LIVE ярилцлага, инфографик, статистик мэдээ зэрэг шинэ контентуудыг хэрэгжүүлснээр пэйжийг 29,417 дагагчаар өсгөж, нийт 82,431 дагагчтай болсон ба фэйсбүүк хуудсанд байршуулсан мэдээ, мэдээлэлд ирүүлсэн 3,274 коммент, асуултад хариулт өгч ажилласан. Цахим хуудасны чатанд хандсан 17,779 иргэний асуудлыг шийдвэрлэжээ.

д/ Хэвлэл мэдээллийн байгууллагуудаар дамжуулан ЭМД-ын үйл ажиллагааг сурталчлах, иргэд, олон нийтэд мэдээ, мэдээлэл тасралтгүй хүргэхэд анхаарал тавьж, 2021 оны жилийн эцсийн байдлаар хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд 203 удаа ярилцлага өгч, эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг сурталчилан таниулав. Үүнээс телевиз-88, мэдээллийн сайт-55, өдөр тутмын сонин-22, радиод 38 удаагийн ярилцлагыг өгсөн байна.

е/ Эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагаа, даатгалын шинэчлэл, ЭМДҮЗ-ийн 03 дугаар тогтоолын талаар Хэвлэл мэдээллийн байгууллагын сэтгүүлч, сурвалжлагчдад мэдээлэл өгөх, ойлголтыг нэмэгдүүлэх “Эрүүл мэндийн даатгалын шинэчлэл ба сэтгүүлчид” уулзалтыг зохион байгууллаа. Энэ арга хэмжээнд хэвлэл мэдээллийн голлох телевиз, сайт, сонин, ФМ радиогийн сэтгүүлч, сурвалжлагч, редакторууд оролцжээ. Үүний үр дүнд Хэвлэл мэдээллийн байгууллагаар даатгалын үйл ажиллагаа, шинэчлэлтэй холбоотой 30 гаруй мэдээ, сурвалжлага, нийтлэл, ярилцлага гарсан.

ё/ Эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомж, эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг хариуцдаг тусламж, үйлчилгээ болон шимтгэл төлөх ач холбогдлын талаар төр болон хувийн хэвшлийн 30 байгууллагын гаруй албан хаагчдад танхимын болон цахим сургалтыг зохион байгуулснаар гэрээт эрүүл мэндийн байгууллагууд нэхэмжлэлээ зөв илгээх, гүйцэтгэлийн санхүүжилтийг цаг тухай бүрт нь шуурхай шийдвэрлэх, ЭМД-ын сангийн хөрөнгийг эмнэлзүйн хувьд үр дүнтэй, эдийн засгийн хувьд үр ашигтай зарцуулах боломж нэмэгдэж байна.

ж/ Иргэд, даатгуулагчдад даатгалын мэдээллийг энгийн, ойлгомжтой байдлаар хүргэх зорилгоор “Нэг сэдэв-Нэг тайлбар”, “ЭМД-ын статистик мэдээлэл”, “ЭМД-ын санхүүжилтийн мэдээ” зэрэг шинэ контентуудыг хэрэгжүүлж жилийн эцсийн байдлаар нийт 619 постер (инфографик, фото, сэдвийн)-ыг бэлтгэн, цахим хаягуудаараа олон нийтэд мэдээлсэн нь давхардсан тоогоор 3.2 сая орчим хүнд хүрсэн байна.

з/ Байгууллагын бодлого, чиглэл болон ЭМД-ын үйл ажиллагаа, ЭМД-ын хууль, түүнд орсон нэмэлт өөрчлөлт, 2021 оны ЭМДҮЗ-ийн 03, 04, 05 дугаар тогтоолуудыг сурталчлах хүрээнд мэдээ, мэдээллийг видео контент хэлбэрээр бэлтгэн түгээж байна. 2021 оны жилийн эцсийн байдлаар 139 видео контент (хөдөлгөөнт постер, видео нэвтрүүлэг, шторк)-ыг бэлтгэн цахим хаягуудаараа

иргэн-даатгуулагчдад мэдээлсэн нь давхардсан тоогоор 1.2 сая орчим хүнийг хамруулсан дүнтэй байна.

и/ Иргэд, даатгуулагчдад ЭМД-ын үйл ажиллагаа, цахим шинэчлэл болон 2021 оны ЭМДҮЗ-өөс гаргасан тогтоолуудын талаар мэдээ, мэдээлэл өгөх, ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор долоо хоног бүрийн Лхагва гарагт ШУУД нэвтрүүлэг буюу 28 удаагийн LIVE-ийг иргэд, даатгуулагчдад дамжуулах зэргээр ажиллаж байна.

й/ Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагын даатгуулагчдад үзүүлсэн тусламж, үйлчилгээний чанарыг ЭМД-ын байгууллагаас хянах харилцааг зохицуулсан “Нэхэмжлэлийн хяналт” гарын авлага, ЭМДҮЗ-ийн 2021 оны “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга журам, шинэчлэн батлах тухай” 03 дугаар тогтоол, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 болон 2021 оны статистикийн эмхэтгэл, Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн байгууллагуудад зориулан ЭМДҮЗ-ийн 04, 05 дугаар тогтоолыг тус тус цахимжуулан иргэд, олон нийтэд мэдээлсэнээр өнөөдрийн байдлаар давхардсан тоогоор 2200 гаруй эмч, мэргэжилтнүүд хамрагдаж, 230 цагийн үзэлттэй байна. Цахим номыг ЭМБ-ын ажилтан, эмч, мэргэжилтнүүд өдөр тутмын ажилдаа гарын авлага болгон ашигладаг болов. Хэдийгээр даатгалын сурталчилгааг иргэд, эрүүл мэндийн байгууллагуудад сурталчилсан тоон үзүүлэлтээр хангалттай байгаа ч иргэн, даатгуулагчийн сэтгэл ханамжид хүрч сурталчилгаа зөвлөгөө очихгүй байгаад дүгнэлт хийж, цаашид ажлаа идэвхжүүлэх арга хэмжээ авахаар төлөвлөж байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, САНАЛ, АНХААРАХ АСУУДАЛ

Хүрсэн үр дүн: Тайлант хугацаанд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагаа Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, түүнд шинээр орсон нэмэлт өөрчлөлтөд нийцүүлэн даатгалын харилцааг боловсронгуй болгох, сангийн удирдлага, менежментийг сайжруулахад холбогдсон журам, зааврыг шинэчлэх, Улсын Их Хурлын байнгын хорооноос гаргасан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж, Коронавируст цар тахлын нөхцөл байдалд даатгалын сангийн үйл ажиллагааг сайжруулахад бүхэлдээ чиглэгдсэн юм.

2021 оны үйл ажиллагааны үр дүнд дараах эерэг хандлага, өөрчлөлт гарч байна.

Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь стратегийн худалдан авалтын тогтолцоонд шилжих үйл явц амжилттай хэрэгжиж байна.

Шинэчлэлийн зорилтын хүрээнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын хяналтын болон төлбөрийн хяналтын тогтолцоог цахимжуулах, улмаар олон улсын эмнэлзүйн удирдамжийн дагуу үзүүлсэн тусламж, үйлчилгээг худалдан авах эхлэл тавигдав.

Эрүүл мэндийн даатгалын сангийн зарцуулалтад гүйцэтгэлийн санхүүжилтийг нэвтрүүлэх ажлыг эхлүүлэв.

2021 онд эрүүл мэндийн даатгалын сангаас гэрээ бүхий төрийн болон хувийн хэвшлийн 331 эрүүл мэндийн байгууллагаас иргэд, даатгуулагчдад үзүүлсэн эмнэлгийн тусламж, үйлчилгээний 5.5 сая тохиолдолд гүйцэтгэлээр нь тооцож 550.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон.

Эрүүл мэндийн даатгалын сангаас төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлэг шинэчлэгдлээ.

ЭМДҮЗ-ийн 2021 оны 03 дугаар тогтоолоор ЭМД-ын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийн жагсаалт, өртгийн жинг шинэчлэн баталсан бөгөөд уг тогтоолд нийт 562 оношийн хамааралтай бүлэг бүхий 120.2 мянган давхардсан оношийг баталсан.

Тусламж үйлчилгээний суурь тарифыг нэмэгдүүллээ.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний суурь тарифыг 21-113 хувиар нэмэгдүүлж, тухайлбал, хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний суурь тарифыг 450.0 мянгаар нэмэгдүүлж 850.0 мянган төгрөг, уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээний суурь тариф 200.0 мянгаар нэмэгдүүлж 450.0 мянган төгрөгт хүргэсэн нь тусламж, үйлчилгээг сайжруулах ач холбогдолтой болсон.

Хамтын төлбөрийг тусламж, үйлчилгээний төрлөөс хамааруулан ялгаатай тогтоов.

Улсын төсвөөс өмнө нь санхүүжүүлж байсан бүх тусламж, үйлчилгээ болон амь, насыг аврах нэн шаардлагатай болон төрөлхийн гажигийн тусламж, үйлчилгээнүүд (хорт хавдар, төрөх эмэгтэйчүүд, халдварт өвчин, төрөлхийн гажиг, түлэгдэлт, харвалт, цочмог шигдээс) хамтын төлбөргүй, мэс заслын тусламж, үйлчилгээ 10-15 хувь, өндөр өртөг бүхий оношилгоо, шинжилгээ 30 хувь. ЭМД-ын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.3-т заасан шимтгэлийг нь төр хариуцах иргэдийг хамтын төлбөрөөс чөлөөлөөд байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас төлбөрийг хариуцах тусламж, үйлчилгээний төрлүүдийг нэмэгдүүллээ.

Монгол улсын хүн амын эрүүл мэндийн эрэлт хэрэгцээг хангах, даатгуулагчийг санхүүгийн эрсдэлээс хамгаалах, ЭМД-ын тусламж, үйлчилгээний хүртээмж, үр ашгийг дээшлүүлэх зорилгоор амбулаторийн үзлэг, оношилгоо, шинжилгээний багц, амбулаторийн жижиг мэс ажилбар, өндөр өртөг бүхий оношилгоо, шинжилгээ, уламжлалтын үзлэг, өдрийн мэс засал, өдрийн уламжлалт эмчилгээ, өдрийн сэргээн засах тусламж, үйлчилгээний төрлүүдийг нэмж бий боллоо.

Эрүүл мэндийн даатгалын байгууллагыг үндэсний хэмжээний бүтцэд шилжүүлж, үйл ажиллагааг нь жигдрүүлэх арга хэмжээ авлаа.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 176 дугаар тогтоолоор агентлагийн орон тооны дээд хязгаарыг 170 байхаар тогтоосныг үндэслэн Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын ерөнхий

газрын бүтцийг шинэчлэн баталж, 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 21 аймаг, Багануур, Налайх дүүрэгт Эрүүл мэндийн даатгалын хэлтсийг байгуулан үйл ажиллагаагаа өргөжүүлсэн.

Эрүүл мэндийн даатгалын хүртээмж нэмэгдлээ.

ЭМД-д хамрагдагсад өмнөх оноос 5.9-өөр нэмэгдэж, 96.8 хувьд хүрлээ. Эрүүл мэндийн даатгалын сангаас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг давхардсан тоогоор 10.3 сая даатгуулагчид хүргэж, 1,159.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон нь өмнөх жилээс 2 дахин өслөө.

Эрүүл мэндийн даатгалын цахим системийг үе шаттайгаар хөгжүүлж байна. Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, “Цахим Монгол” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, цахим системд холбогдсон бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудыг иргэд, даатгуулагчдад үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэл, үр дүнд үндэслэн санхүүжүүлэх шинэчлэлийн хүрээнд ЭМД-г “ГТСМТТ” УҮГ-ын “Нэвтрэлтийн нэгдсэн систем”-д холбогдож, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний API сервисээр ажиллах болов.

Анхаарах асуудал, санал:

- Цаашдаа эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийг иргэн, даатгуулагч байгууллагаас хуульд заасан шимтгэлээр бүрдүүлж, тодорхой нөхцөл шаардлагаар зарцуулдаг ЭМД-ын сангийн хөрөнгө, төрөөс иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардлыг тус бүрд нь орлого зарлагаар нь төсвийг батлах нь зүйтэй гэсэн саналтай байна. Энэ талаар Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлөөс удаа дараа санал тавьж байсан болно. Энэ нь эрүүл мэндийн даатгалын санг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулагдаж буй эсэхэд хяналт тавьж, хариуцлагыг өндөржүүлэх ач холбогдолтой.

- Одоогийн Эрүүл мэндийн даатгалын бүтэц, зохион байгуулалтын тогтолцоогоор даатгалын сангийн төлөвлөлт, захиран зарцуулалт болон гүйцэтгэлд хяналт тавих субъектийн эрх үүргийг илүү тодорхой болгох, хариуцлага хүлээх шаардлагыг өндөржүүлэх замаар Эрүүл мэндийн даатгалын сангийн менежмент зөв явагдаж, үр ашгийг нь дээшлүүлэх, нийгмийн зүгээс сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг бүхэлд нь сайжруулах.

---ooOoo---